



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.11.12 № 4/138 ЧАГ-ИАГ/2013/04-ИА.

Газар эзэмших эрхийг хүчингүй  
болгох тухай

Дархан-Уул аймгийн Аудитын газрын 2012 онд хийсэн “Газар олголт, ашиглалттай холбоотой харилцааны зохион байгуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаас илрүүлсэн зөрчлийг арилгах талаар аймгийн удирдлага ямар нэгэн арга хэмжээг аваагүй байна.

Мөн Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас хийсэн “Дархан-Уул аймаг дахь газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын байдал, хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар 2012 оны 11, 12 сар, 2013 оны эхний 5 сарын байдлаар ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газруудыг хавсралтад дурьдсан нэр бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад төсөл, сонгон шалгаруулалтгүйгээр Засаг дарга захирамж гаргаж олгосон нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дархан-Уул аймгийн Аудитын газрын 2012 оны 01/14, 02/15 тоот болон Үндэсний аудитын газраас өгсөн албан шаардлагыг биелүүлж, хавсралтад заагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хүчингүй болгох;
2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудаас бусад газрыг сумын ИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ашиглуулах тухай сумын Засаг даргын газрын харилцааны талаарх бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
3. Өмчлөгдснөөс бусад газрыг бусдад зарах, энэ талаар хэвлэл мэдээллээр явж буй зар мэдээнд тавих хяналтыг сайжруулж, таслан зогсоох арга хэмжээ авах.
4. Газрын харилцааны талаар болон аймгийн ИТХ-аас баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүнд тусгагдсан газрын байршил зэргийг ил тод болгох ойлгомжтой байлгах мэдээлэх.

5. Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг гарган 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат, Газрын харилцаа, барилга хот байгууллалтын газрын дарга З.Мөнх-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА

